



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2024 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 353

Улаанбаатар хот

**“Төрийн орон сууцны корпораци” ХХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус
гишүүн томилох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. “Төрийн орон сууцны корпораци” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хорооноос ирүүлсэн дүгнэлт, Авлигатай тэмцэх газрын 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 05/10342 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг тус тус харгалзан компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр Дамдинсүрэнгийн Алтангэрэлийг 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн томилсугай.

2. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг судалж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг хараат бус гишүүнд, мэдүүлгийг хуульд заасан хугацаанд гаргуулан авахыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

133001855

17-r huraldaan.docx